



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/63/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 260512 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)  
Гэрээгээр гүйцэтгэсэн: Мүүрь Аудит ХХК-ийн  
Захирал У.Оюунаа  
Утас: 976-7015 0003 Цахим хаяг: [info@moore-mongolia.mn](mailto:info@moore-mongolia.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	14
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	15
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	16
4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	19
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	20
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	20
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	21
8. Аудитын илрүүлэлт .....	22
8.1 Залруулсан алдаа.....	22
8.2 Төлбөрийн акт.....	22
8.3 Албан шаардлага.....	22
8.4 Зөвлөмж.....	23
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	25

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗЗА	Авто зам засвар арчлалт
ГСАЗ	Гашуун сухайт авто зам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ  
О.ХУЛАН ТАНАА

2022.03.15 № 07/609  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хараат бус аудиторын тайлан

#### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв толилуулаагүй байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь сөрөг дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах зөрчлүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

- Хөгжлийн банкаас авсан зээлээс хугацаандаа төлөөгүй зээлийн үлдэгдэл 18,889.8 сая төгрөг, зээлийн хүүгийн өр төлбөр 8,774.7 сая төгрөг байгаа нь тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварт сөргөөр нөлөөлөх үр дагавартай;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 228 тоот тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас тогтоосон 766.6 сая төгрөгийн ногдол ашиг, 2019 оны ногдол ашгийн үлдэгдэл 0.8 сая төгрөгийг ногдол ашгийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
- Тайлант онд хүлээн авсан 54.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг бүртгэлд тусгаагүй;
- Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилт судалгааны ажлыг хийх гэрээний дүнгээр Хайгуул үнэлгээний хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрснөөс шалтгаалан хэрэгжээгүй гэрээний үлдэгдлээр хайгуул үнэлгээний хөрөнгө ба өр төлбөрийг 519.0 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Хөгжлийн банкны зээлийн 2022 онд төлөгдөх 17,520.0 сая төгрөгийг урт хугацаат зээлээр толилуулсан;

Эдгээр нь Санхүүгийн тайлагналын Онолын үзэл баримтлал, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр стандартад нийцээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтыг зөрчсөн ба толилуулга ба тодруулга, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

### **Асуудлыг онцолсон зүйл**

Шалгагдагч байгууллага нь 2019 онд Хөгжлийн банкнаас 157,517.7 сая төгрөгийн зээл авсан. Зээлийн эргэн төлөлт 16,150.2 сая төгрөг, тайлант оны эцсээрх зээлийн үлдэгдэл 141,367.5 сая төгрөг байна. Үүнээс 2022 онд зээл ба зээлийн хүүгийн хамт 45,184.6 сая төгрөгийг төлөхөөр байна. Урт хугацаанд төлөх зээлийн үлдэгдэл 104,957.7 сая төгрөг бөгөөд 2028 онд багтаан төлөх үүрэгтэй.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх хуулийн дагуу Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалсан Эрдэнэс-1 бондын өглөг 929,861.0 сая төгрөг ба уг бондыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төлөхөөр байна. Тайлант онд Эрдэнэс-2, Эрдэнэс-3 бондын төлбөрт 215,494.6 сая төгрөг төлжээ.

### **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 41 дугаартай тогтоолоор 2021 онд нийт орлогыг 72,656.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 55,797.2 сая төгрөгөөр, татварын зардлыг 3,314.7 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 13,544.2 сая төгрөг байх төсөв баталжээ.

Гүйцэтгэлээр орлого 29,480.9 сая төгрөг, нийт зардал 51,188.4 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр алдагдал 20,146.4 сая төгрөгт хүрсэн байна. Төсөвлөсөн орлого 59.4 хувь буюу 43,175.2 сая төгрөгөөр тасарсан нь коронавируст халдварын улмаас БНХАУ хилийн хориг тавьж, экспортын нүүрс тээвэр буурч, Гашуунсухайтын автозамын хураамжийн орлого тасарсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 14,910.2 сая төгрөг төлөвлөснөөс хөрөнгө худалдан авахад 221.8 сая төгрөг, автозамын хучилт, шинэчлэлтэд 8,457.5 сая төгрөг зарцуулж, 3 төсөл хөтөлбөрт 1,224.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн тайланд 7 зорилго 18 зорилтын хүрээнд 149 багц ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 71.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,617,880,978.34	815,378,166.85
1.1.2	Дансны авлага	11,638,769,454.03	1,518,182,329.36
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	186,362,528.98	476,948,068.73
1.1.4	Бусад авлага	222,901,143,586.06	12,901,377,578.57
1.1.6	Бараа материал	41,217,988.44	45,264,342.19
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,988,908,308.09	316,372,622.56
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>245,374,282,843.94</b>	<b>16,073,523,108.26</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	172,307,588,985.45	166,581,976,925.43
1.2.2	Биет бус хөрөнгө	481,904,613.54	528,978,754.92
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,128,898,051,467.00	9,128,897,051,467.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1,760,459,135.59	1,776,731,862.86
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	3,691,740,440.99	8,598,656,617.61
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	816,876,995,092.26	864,064,607,998.38
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>10,124,016,739,734.80</b>	<b>10,170,448,003,626.20</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,369,391,022,578.70</b>	<b>10,186,521,526,734.50</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	1,201,261,563.91	9,841,718,815.10
2.1.1.2	Цалингийн өглөг	5,185,774.92	902,886.35
2.1.1.3	Татварын өр	5,109,454,521.10	3,147,326,205.98
2.1.1.5	Богино хугацаат зээл	26,280,000,000.00	19,601,008,942.90
2.1.1.6	Хүүний өглөг	787,731,920.58	8,774,687,604.28
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	60,000.00	14,700,631.72
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	215,223,160,146.29	1,479,692,518.35
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>248,606,853,926.80</b>	<b>42,860,037,604.68</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	149,425,574,576.44	147,921,240,525.60
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	813,608,934,249.78	858,139,991,926.97
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>963,034,508,826.22</b>	<b>1,006,061,232,452.57</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,211,641,362,753.02</b>	<b>1,048,921,270,057.25</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	100,000,000.00	100,000,000.00
2.3.3	- хувьцаат	3,000,000.00	3,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	17,175,601,462.26	17,175,601,462.26
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	9,128,284,251,467.00	9,128,284,251,467.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	12,186,806,896.42	(7,962,596,252.03)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>9,157,749,659,825.68</b>	<b>9,137,600,256,677.23</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,369,391,022,578.70</b>	<b>10,186,521,526,734.50</b>



**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	62,565,064,449.27	26,291,787,091.91
2	Борлуулалтын өртөг	10,828,130,820.92	23,809,108,549.30
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>51,736,933,628.35</b>	<b>2,482,678,542.61</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	2,832,715,477.34	3,026,691,867.46
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	58,428,772.91	162,459,245.13
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	28,725,037,024.10	6,002,687,298.45
11	Санхүүгийн зардал	16,054,724,212.07	21,049,790,262.48
12	Бусад зардал	354,743,063.87	339,751,866.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(975,207,751.90)	118,293,873.39
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>8,518,365,826.66</b>	<b>(21,602,105,899.22)</b>
19	Орлогын татварын зардал	851,836,582.67	(1,455,702,750.74)
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>7,666,529,243.99</b>	<b>(20,146,403,148.48)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>7,666,529,243.99</b>	<b>(20,146,403,148.48)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>65,456,208,699.52</b>	<b>29,480,938,204.50</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>7,666,529,243.99</b>	<b>(20,146,403,148.48)</b>



**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>103,000,000.00</b>	<b>17,175,601,462.26</b>	<b>9,128,284,251,467.00</b>	<b>6,557,277,652.56</b>	<b>9,152,120,130,581.82</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(2,037,000,000.00)	<b>(2,037,000,000.00)</b>
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>103,000,000.00</b>	<b>17,175,601,462.26</b>	<b>9,128,284,251,467.00</b>	<b>4,520,277,652.56</b>	<b>9,150,083,130,581.82</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг				7,666,529,243.86	<b>7,666,529,243.86</b>
5	<b>2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>103,000,000.00</b>	<b>17,175,601,462.26</b>	<b>9,128,284,251,467.00</b>	<b>12,186,806,896.42</b>	<b>9,157,749,659,825.68</b>
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				<b>(3,000,000.00)</b>	<b>(3,000,000.00)</b>
7	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>103,000,000.00</b>	<b>17,175,601,462.26</b>	<b>9,128,284,251,467.00</b>	<b>12,183,806,896.42</b>	<b>9,157,746,659,825.6</b>
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(20,146,403,148.48)	<b>(20,146,403,148.48)</b>
9	<b>2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>103,000,000.00</b>	<b>17,175,601,462.26</b>	<b>9,128,284,251,467.00</b>	<b>(7,962,596,252.06)</b>	<b>9,137,600,256,677.23</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>59,462,486,648.76</b>	<b>36,498,734,932.53</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	59,440,050,624.76	36,462,674,689.53
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	801,000.00
	Бусад мөнгөн орлого	22,436,024.00	35,259,243.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>53,216,708,031.00</b>	<b>252,051,300,677.63</b>
	Ажиллагчдад төлсөн	3,364,429,368.96	2,891,604,341.47
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	846,384,322.98	827,115,480.25
	Бараа материал худалдан авахад төлсөн	285,557,497.65	40,978,561.60
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	91,845,701.98	108,638,552.40
	Хүүгийн төлбөрт төлсөн	17,230,192,489.20	5,800,713,780.13
	Татварын байгууллагад төлсөн	4,488,791,803.88	7,406,047,340.44
	Бусад мөнгөн зарлага	26,909,506,846.35	234,976,202,621.34
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>6,245,778,617.76</b>	<b>(215,552,565,745.10)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,230,536,119.45</b>	<b>217,489,018,330.01</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		1,500,000,000.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,721,115,316.65	215,976,349,736.99
	Хүлээн авсан хүүгийн орлого	509,420,802.80	12,668,593.02
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>267,717,325.00</b>	<b>271,675,461.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	197,205,905.00	209,171,535.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	70,511,420.00	62,503,926.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,962,818,794.45</b>	<b>217,217,342,869.01</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,411,008,637.85</b>	<b>514,495.29</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,334,001,421.52	-
	Бусад	77,007,216.33	514,495.29
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>9,112,866,854.49</b>	<b>8,467,794,430.68</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	9,109,297,816.07	8,467,073,946.68
	Бусад	3,569,038.42	720,484.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(7,701,858,216.64)</b>	<b>(8,467,279,935.39)</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>2,506,739,195.57</b>	<b>(6,802,502,811.48)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>5,111,141,782.77</b>	<b>7,617,880,978.34</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7,617,880,978.34</b>	<b>815,378,166.85</b>

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

№	Үндсэн үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он			
				Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
<b>Нэг. Нийт орлого</b>		Мян.төг	<b>65,456,208.70</b>	<b>72,656,162.57</b>	<b>29,480,938.20</b>	<b>(43,175,224.36)</b>	<b>40.6</b>
1.1	Замын хураамжийн орлого	Мян.төг	60,107,037.24	67,344,097.43	23,997,909.01	(43,346,188.42)	35.6
1.2	Менежментийн төлбөр	Мян.төг	2,196,109.71	2,018,224.33	2,067,887.15	49,662.82	102.5
1.3	Шивээ Овоо талбай ашигласны төлбөр	Мян.төг	224,400.00	224,400.00	224,400.00	-	100.0
1.4	Бусад орлого	Мян.төг	95,946.27	-	164,050.18	164,050.18	100.0
1.5	Хүүгийн орлого	Мян.төг	2,832,715.48	3,069,440.80	3,026,691.87	(42,748.94)	98.6
<b>Хоёр. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааны нийт зардал</b>		Мян.төг	<b>55,962,614.08</b>	<b>55,797,231.14</b>	<b>51,188,402.35</b>	<b>(4,608,828.80)</b>	<b>91.7</b>
<b>А. Гашуунсухайтын автозамын зардал</b>		Мян.төг	<b>25,721,974.61</b>	<b>26,083,932.24</b>	<b>23,576,915.66</b>	<b>(2,507,016.58)</b>	<b>90.4</b>
2.1	Зээлийн хүүгийн зардал	Мян.төг	14,893,843.79	13,229,483.96	13,797,543.63	568,059.67	104.3
2.2	"ГСАЗ" ХХК-ийн гэрээний дагуу зардал	Мян.төг	9,579,574.80	7,755,566.14	5,743,373.18	(2,012,192.95)	74.1
2.3	ГСАвто замын гэрээт цагдаагийн зардал	Мян.төг	-	1,550,000.00	1,069,756.47	(480,243.53)	69.0
2.4	Гашуун сухайт авто замын их засварын урсгал зардал	Мян.төг	1,248,556.02	3,548,882.14	2,966,242.37	(582,639.77)	83.6
<b>Б.Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны зардал</b>		Мян.төг	<b>26,188,127.54</b>	<b>28,474,945.25</b>	<b>20,105,351.64</b>	<b>(8,369,593.60)</b>	<b>70.6</b>
2.5	Цалингийн зардал	Мян.төг	3,108,393.67	3,489,096.00	3,157,148.04	(331,947.96)	90.5
2.6	Нийгмийн даатгалын шимтгэл	Мян.төг	397,719.43	471,027.96	417,398.71	(53,629.25)	88.6
2.7	ТУЗ-ийн зардал	Мян.төг	245,449.13	280,512.00	180,973.56	(99,538.44)	64.5
2.8	ТУЗ-ийн дэргэдэх хяналтын нэгж	Мян.төг	179,911.53	331,457.16	175,560.85	(155,896.31)	53.0
2.9	Оффисын зардал	Мян.төг	627,846.66	712,399.32	673,685.23	(38,714.09)	94.6
2.10	Бичиг хэрэг	Мян.төг	44,002.22	47,673.36	38,049.72	(9,623.63)	79.8
2.11	Хангамжийн материал	Мян.төг	27,282.44	39,534.09	31,390.92	(8,143.17)	79.4
2.12	Хурал зөвлөгөөн, уулзалтын зардал	Мян.төг	169,485.54	197,500.00	2,832.40	(194,667.60)	1.4
2.13	Мэдээлэл, зар сурталчилгаа	Мян.төг	296,816.25	473,120.00	165,581.58	(307,538.43)	35.0

2.14	Гадаад албан томилолт	Мян.төг	7,212.89	116,156.00	-	(116,156.00)	-
2.15	Дотоод албан томилолт	Мян.төг	47,968.02	94,765.40	16,901.84	(77,863.56)	17.8
2.16	Гэрээт ажил	Мян.төг	351,553.52	657,944.86	150,816.38	(507,128.49)	22.9
2.17	Авто машинтай холбоотой зардал	Мян.төг	147,909.20	206,738.63	82,742.29	(123,996.34)	40.0
2.18	Сургалтын зардал	Мян.төг	32,201.90	132,625.00	6,308.51	(126,316.49)	4.8
2.19	Авлигын тухай сурталчлан таниулах зардал	Мян.төг	-	3,000.00	-	(3,000.00)	-
2.20	Шуудан, харилцаа холбоо	Мян.төг	52,722.65	52,500.00	40,466.97	(12,033.03)	77.1
2.21	Ном, хэвлэл захиалга	Мян.төг	6,818.18	11,866.35	4,810.09	(7,056.26)	40.5
2.22	Тайлан үйлчилгээний зардал	Мян.төг	-	25,000.00	-	(25,000.00)	-
2.23	Нийгмийн арга хэмжээний зардал	Мян.төг	198,194.38	208,000.00	88,832.70	(119,167.30)	42.7
2.24	Элэгдлийн зардал	Мян.төг	19,997,610.77	19,521,431.39	14,366,840.09	(5,154,591.31)	73.6
2.25	Татвар, төлбөр, шимтгэл, хураамж, даатгал	Мян.төг	38,897.28	160,597.73	48,951.77	(111,645.96)	30.5
2.26	Хариуцлагын даатгал	Мян.төг	-	100,000.00	-	(100,000.00)	-
2.27	Магадлашгүй зардал	Мян.төг	162,663.71	-	-	-	-
2.28	Аудитын төлбөр	Мян.төг	47,421.17	770,000.00	320,121.01	(449,878.99)	41.6
2.29	Үйлчилгээний эрх	Мян.төг	46.99	65,400.00	35,989.01	(29,410.99)	55.0
2.29	Баялгийн сан болон, стратегийн шилжилтийн зардал	Мян.төг	-	250,000.00	99,950.00	(150,050.00)	40.0
2.30	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал	Мян.төг	-	56,600.00	-	(56,600.00)	-
<b>Б. Нэмэлт зардал</b>		Мян.төг	<b>4,052,511.93</b>	<b>1,238,353.66</b>	<b>7,506,135.05</b>	<b>6,267,781.39</b>	<b>606.1</b>
2.31	АХБ-ны төслийн дотоод санхүүжилтийн зардал	Мян.төг	97,284.60	-	20,200.00	20,200.00	100.0
2.32	АХБ-ны зээлийн шимтгэл, хүүний зардал	Мян.төг	458,834.94	536,222.11	290,450.43	(245,771.68)	54.2
2.33	АХБ-ны зээлийн батлан даалтын төлбөр	Мян.төг	701,998.50	702,131.55	7,195,484.63	6,493,353.07	1024.8
2.34	АХБ-ны төслийн гадаад санхүүжилтийн зардал	Мян.төг	2,794,393.89	-	-	-	-
<b>Гурав. Бусад ашиг (алдагдал)</b>		Мян.төг	<b>(975,228.80)</b>	<b>-</b>	<b>105,358.25</b>	<b>105,358.25</b>	<b>100.0</b>
3.1	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	Мян.төг	(975,228.80)	-	118,293.87	118,293.87	100.0

3.2	Бусад ашиг (алдагдал)	Мян.төг	-	-	(12,935.63)	(12,935.63)	100.0
<b>Дөрөв. Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>		Мян.төг	<b>8,518,365.83</b>	<b>16,858,931.42</b>	<b>(21,602,105.90)</b>	<b>(38,461,037.32)</b>	<b>(128.1)</b>
4.1	Орлогын албан татвар	Мян.төг	851,836.58	3,314,732.86	301,403.04	(3,013,329.82)	9.1
4.2	Тайлант үеийн алдагдлаас үүссэн хойшлогдсон татварын орлого	Мян.төг	-	-	1,757,105.79	1,757,105.79	100
<b>Тав. Цэвэр ашиг (алдагдал)</b>		Мян.төг	<b>7,666,529.24</b>	<b>13,544,198.57</b>	<b>(20,146,403.15)</b>	<b>(33,690,601.72)</b>	<b>(148.7)</b>
	* ТУЗ-тай холбоотой хөрөнгө оруулалт	Мян.төг	-	4,000.00	3,239.82	(760.18)	81.0
	** ТУЗ-ийн дэргэдэх хяналтын нэгжтэй холбоотой хөрөнгө оруулалт	Мян.төг	-	7,900.00	5,696.36	(2,203.64)	72.1

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах, өр төлбөр ба хөрөнгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 18-наас 2022 оны 03 дугаар сарын 18-ны хооронд Мүүрь Аудит ХХК-ийн баталгаажуулах үйлчилгээний менежер П.Нарантуяа, аудитор М.Гантуяа, аудиторын туслах Г.Отгонзаяа, Х.Өсөх-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Н.Гэрэлчимэг, захирал У.Оюунаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Мүүрь Аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 01/87 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Учир нь тайлант онд Компанийн гүйцэтгэх удирдлага, санхүү эрхэлсэн дэд захирал, ерөнхий нягтлан бодогч нар ажлаас чөлөөлөгдсөн нь дотоод хяналт зохистой хэрэгжихэд сөрөг нөлөө үзүүлсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тухайн баримт бичгийг баталснаас хойш СТОУС-д орсон өөрчлөлт, байгууллагын үйл ажиллагаа, санхүү бүртгэлд шинээр нэмэгдсэн үйл явдлыг хамруулан нэмэлт өөрчлөлт хийгээгүй байна. Тухайлбал: урт хугацаат өр төлбөр буюу бондын бүртгэл, охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын хэмжилт, үнэ цэнийн бууралт ба өмчийн арга ашиглаж буй тохиолдолд мэдэгдэхүйц нөлөөг хэрхэн үнэлж тогтоох, үндсэн хөрөнгө буюу замын капиталжуулалт, түүний хэмжилт, хүлээн зөвшөөрөлт, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд, СТОУС-16 Түрээсийн стандартын талаар нарийвчлан оруулаагүй байна.

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн дэргэд 3 хүний бүрэлдэхүүнтэй Аудитын хороо ажилладаг бөгөөд уг хороо нь ТУЗ-өөс баталсан дүрмийн хүрээнд 2021 онд 6 бүлэг ажил төлөвлөж батлуулснаас биелэлт 70 хувьтай байна. Тайлант онд Коронавируст халдварт цар тахлын улмаас хатуу хөл хорио тогтоосноос биечлэн хийгдэх ажлууд хэрэгжээгүй, хойшилсон, гүйцэтгэх удирдлагын тогтворгүй байдлаас шалтгаалан үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа алдсан зэргээс төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс Монгол ХХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 55,962.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 559.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэс Монгол ХХК-ийн зорилго нь ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэн, хувьцаа эзэмшигчийн үр өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг өсгөхөд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд эрэх, хайх, ашиглах болон эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хувьцаа эзэмшигчийн төлөөлөл, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших, ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг холбогдох хуулийн дагуу төвлөрүүлж, хуваарилах;
- Ашигт малтмалын орд ашиглалтын үеийн геологийн судалгаа, эрдэм шинжилгээ, эрэл, хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээр гүйцэтгэх, ашигт малтмалын ордыг дангаараа болон бусад этгээдтэй хамтран ашиглах, Засгийн газраас эрх олгосноор орд ашиглах гэрээ байгуулах, ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах чиглэлээр ашигт малтмалын ордын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших, бүхлээр нь, эсхүл тодорхой хэсгийг буцаан өгөх, бусдад шилжүүлэх, шилжүүлэн авах, барьцаалах, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, тооллогыг зохион байгуулахад оролцох, ашигт малтмалын орд ашиглалттай холбоотой аливаа эд хөрөнгө, тоног төхөөрөмж болон оюуны өмчийн эрхийг эзэмших, ашиглах, түрээслэх, түрээслүүлэх, худалдаж авах,



- худалдах, стратегийн хөрөнгө оруулагчийг татан оролцуулах асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Хөрөнгө төвлөрүүлэх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зээл авах, өрийн бичиг (бонд) гаргах, бусад хэлбэрээр хөрөнгө оруулалтыг татах, хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдэд зээл олгох, хөрөнгө оруулах, хөрөнгийн баталгаа гаргах;
  - Уул уурхайн бүтээгдэхүүн (олборлосон, баяжуулсан, боловсруулсан)-ийг гадаад, дотоод зах зээлд борлуулах, энэ талаар хэлцэл хийж гэрээ байгуулах, бүтээгдэхүүний экспорт, импорттой холбогдуулан хилийн боомт, нэвтрэх гарцын барилга байгууламж барих, эзэмших, ашиглах;
  - Ашигт малтмалын орд ашиглалтын техник-эдийн засгийн үндэслэл, нөөцийн үнэлгээ, хөрөнгө, санхүүгийн төлөвлөлт хийх; ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбогдуулан ордын талаарх мэдээллийг дотоод, гадаадад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах, ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааг дотоод, гадаадын хөрөнгийн биржид бүртгүүлэн, арилжаалахад оролцох зэргээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай. Өмчийг 100 хувь Монгол улсын Засгийн газар эзэмшиж байна.

#### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Эрдэнэс Монгол ХХК нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 52 дугаар тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газрын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дах заалт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;” компанийн удирдлагыг ТУЗ-ийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.8 дах заалт “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох” гэсэн заалтуудтай нийцэж байна.

ТУЗ нь Монгол улсын Засгийн газраас томилсон ердийн 5 гишүүн, компанийн гүйцэтгэх удирдлага, хараат бус 3, нийт 9 гишүүнтэй бөгөөд компанийн дүрэмд зааснаар улиралд 1-ээс доошгүй удаа, Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу хуралдаж, уг хуулийн 76 дугаар зүйл болон дүрэмд заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэгтэй.

Тайлант онд ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, 10 удаагийн хурлаар 52 асуудлыг хэлэлцэж, 22 тогтоол, 33 хурлын тэмдэглэл гарсан байна.

ТУЗ-ийн ердийн гишүүдийн сарын цалин нь 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна. Харин хараат бус 3 гишүүний сарын цалинг 1.5 сая төгрөгөөр тогтоосон байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу зарим зардлыг хэмнэх, нэмэгдэл цалинг бууруулах, нэн шаардлагатайгаас бусад худалдан авалтын төлөвлөгөөг цуцлах арга хэмжээг авсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 болон 2 дох хэсэгт орсон өөрчлөлт (2021 оны 6 дугаар сарын 11)
- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоол “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоол

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрдэнэс Монгол ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,617,881.0	815,378.2	(6,802,502.8)
Авлага	234,726,275.6	14,896,508.0	(219,829,767.6)
Урьдчилгаа	2,988,908.3	316,372.6	(2,672,535.7)
Бараа материал	41,218.0	45,264.3	4,046.4
Үндсэн хөрөнгө	172,307,589.0	166,581,976.9	(5,725,612.1)
Биет бус хөрөнгө	481,904.6	528,978.8	47,074.1
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,128,898,051.5	9,128,897,051.5	(1,000.0)
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1,760,459.1	1,776,731.9	16,272.7
Хойшлогдсон татварын хөрөнгө	3,691,740.4	8,598,656.6	4,906,916.2
Бусад эргэлтийн бус хөрөнгө	816,876,995.1	864,064,608.0	47,187,612.9
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>10,369,391,022.6</b>	<b>10,186,521,526.7</b>	<b>(182,869,495.8)</b>
Богино хугацаат өглөг	221,539,122.0	14,484,341.1	(207,054,780.9)
Богино хугацаат зээл ба хүүгийн өглөг	27,067,731.9	28,375,696.5	1,307,964.6
Урт хугацаат өглөг	963,034,508.8	1,006,061,232.5	43,026,723.7
Эздийн өмч	9,157,749,659.8	9,137,600,256.7	(20,149,403.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>10,369,391,022.6</b>	<b>10,186,521,526.7</b>	<b>(182,869,495.8)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, өр төлбөр, мөнгөн хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

1. Мөнгөн хөрөнгө 815.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч 6,802.5 сая төгрөгөөр буурсан нь замын хураамжийн орлого тасарснаас шалтгаалсан байна. Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.01 сая төгрөг, Голомт, Хаан, Хас, Худалдаа хөгжлийн банк дахь төгрөгийн харилцах дансанд 774.9 сая төгрөг, Голомт банк дахь валютын харилцах дансанд 14,145.19 ам доллар буюу 40.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2. Авлагын үлдэгдэл 219,829.8 сая төгрөгөөр буурч, 14,896.5 сая төгрөг болсон байна. Үүнд:
  - Авлагын үлдэгдэлд охин компаниуд болон холбоотой талаас авах авлага 11,880.9 сая төгрөг байгаа нь авлагын үлдэгдэлд 79.7 хувийг эзэлж байна. Тайлант онд охин компани болон төсөл хөтөлбөрт 5,099.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүжилт олгож, 3,258.8 сая төгрөгийн хүүгээр авлага нэмэгдүүлсэн ба Эрдэнэс силвер ресурс ХХК нь Эрдэнэс-2, Эрдэнэс-3 бондын төлбөрт 215,494.7 сая төгрөгийг төлсөн нь авлагын өөрчлөлтөд голлон нөлөөлжээ.
  - НӨАТ-ын авлага 1,273.9 сая төгрөг, НДШ-ийн авлага 0.6 сая төгрөг бөгөөд нийт авлагын дүнд 8.5 хувийг эзэлж байна.
  - Дансны авлагын үлдэгдэл 1,540.4 сая төгрөг, үүнээс хугацаандаа байгаа 1,377.5 сая, хугацаа хэтэрсэн 162.9 сая төгрөгийн авлага байна. Үүнд: 2 хүртэлх жилийн насжилттай 14 байгууллагаас авах 103.1 сая, 3 жилийн насжилттай 10 байгууллагаас авах 59.8 сая төгрөгийн авлага багтсан.
  - Дансны авлагын насжилтад суурилан нөөцийн аргаар тооцсон найдваргүй авлагын хасагдуулга 22.3 сая төгрөг.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зааснаар худалдааны бус авлагад нөөц байгуулдаггүй бөгөөд найдваргүй болсон үед шууд данснаас хасдаг. Тайлант онд найдваргүйд тооцож данснаас хассан авлага байхгүй.

3. Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл 316.4 сая төгрөг болж өмнөх оноос 2,672,5 сая төгрөгөөр буурсан нь 2018 онд Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-д Засгийн газрын 2017 оны 177 тоот тогтоолын хүрээнд Бүгд найрамдах Энэтхэг улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавих, дүгнэлт гаргахад шаардагдаж буй хөрөнгийг санхүүжүүлсэн 335,789 ам.доллар буюу 841.5 сая төгрөг, Эрчим хүчний Экспортын Шивээ-Энержи цогцолбор төсөлд оруулсан хөрөнгө оруулалт 1,022.3 сая төгрөгийг дахин ангилж, тухайн компани болон охин компаниас авах авлагын данс руу шилжүүлсэн, 808.8 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

4. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2018-2020 онд шилжүүлсэн 2,988.9 сая төгрөгийн тооцооноос тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 837.1 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч холбогдох зардлын дансанд, 1,863.7 сая төгрөгийг охин компаниас авах авлага дансанд шилжүүлэн, 22.3 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг холбогдох ажилтнаас суутган барагдуулсан байна.

5. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 166,581.9 сая төгрөг, үүнээс 150,991.5 сая төгрөг буюу 90.6 хувь нь Тавантолгой Гашуунсухайт чиглэлийн хүн даацын авто зам байна. Тайлант онд хөрөнгө оруулалтын төсвийн хүрээнд Гашуунсухайт чиглэлийн хүнд даацын авто замд хийсэн 8,457.5 сая төгрөгийн асфальт бүрэлт, шинэчлэлтийн ажлыг капиталжуулж, шинээр 168.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1816 дугаартай тогтоолоор нийт 98.3 сая төгрөгийн өртөгтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн компьютер, тавилга эд хогшлыг данснаас хассан байна.

6. Биет бус хөрөнгө 528.9 сая төгрөг болж, 47.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд лицензийн төлбөрт төлсөн 62.5 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, тайлант үед байгуулсан 15.4 сая төгрөгийн хорогдуулгаар буурсан байна. ТӨБЗГ-ын А-1/1816 дугаартай тогтоолоор

элэгдлээрээ өртгөө нөхсөн 73.1 сая төгрөгийн лиценз болон программыг данснаас хассан байна.

7. Охин болон хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалт 9,128,897.1 сая төгрөг бүртгэгдсэн бөгөөд тайлант онд материаллаг өөрчлөлт ороогүй байна. Урт хугацаат хувьцаагаарх хөрөнгө оруулалтыг санхүүжигчийн хувьд мэдэгдэхүйц нөлөөтэй бол өмчийн аргаар, мэдэгдэхүйц нөлөөгүй бол бодит үнэ цэнээр бүртгэлд тусгахаар заасан боловч мэдэгдэхүйц нөлөөг хэрхэн үнэлэх, өмчийн арга хэрэглэсэн үед хэрхэн тохируулах, бодит үнэ цэнийг хэрхэн тогтоож, бүртгэх талаар нарийвчлан заагаагүй байна.

8. Үндсэн хөрөнгийн элэгдлийн санхүү болон татварын суурийн зөрүүгээс хойшлогдсон татварын хөрөнгө үүсгэсэн бөгөөд тайлант үеийн алдагдлаас үүссэн 1,757.1 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэнээр, 8,598.6 сая төгрөгт хүрсэн байна.

9. Бусад эргэлтийн бус хөрөнгө 864,064.6 сая төгрөг, өмнөх онтой харьцуулахад 47,187.6 сая төгрөгөөр өссөн нь охин компаниас авах авлага 2,901.4 сая төгрөгөөр, бондын авлагын хямдруулалтын тохируулга 44,286.3 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Бусад эргэлтийн бус хөрөнгийн 90.4 хувь буюу 780,823.3 сая төгрөг нь бондын авлага, 8.5 хувь буюу 73,468.4 сая төгрөг нь охин компанид олгосон зээлийн санхүүжилтийн авлага, 1.0 хувь буюу 8,816.3 сая төгрөг нь охин компанид олгосон санхүүжилтийн хүүгийн авлага байна.

10. Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 42,860.0 сая төгрөг, Эрдэнэс-2 ба Эрдэнэс-3 бондын төлөлт 215,494.7 сая төгрөгөөр буурч, санхүүжилт, мөнгөн урсгалын дутагдалтай байдлаас зам засвар, арчлалтын компаниудад төлж чадаагүй 8,439.9 сая төгрөг, хугацаандаа төлж чадаагүй зээл ба зээлийн хүүгийн өсөлтөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн 66.2 хувь буюу 28,375.7 сая төгрөг нь зээл ба зээлийн хүүгийн өр төлбөр, 5.2 хувь буюу 3,147.3 сая төгрөг татварын өр байна.

11. Урт хугацаат өр төлбөр 1,006,061.2 сая төгрөг болж өмнөх оноос богино хугацаат зээл рүү шилжүүлсэн 19,024.0 сая төгрөгөөр буурч, Монголбанканд төлөх Эрдэнэс-1 бондын хямдруулалтын тохируулга 41,690.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

12. Шалгагдагч байгууллага нь 2019 онд Хөгжлийн банкнаас авсан жилийн 9.5 хувийн хүүтэй 157,517.7 сая төгрөгийн зээлийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн хүнд даацын тусгай зориулалтын 239 км автозам, Гашуунсухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалт бүхий дэд бүтцийг Эрдэнэс Монгол ХХК-ийн мэдэлд шилжүүлэн авсны төлбөрт зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт 16,150.2 сая төгрөг, зээлийн үлдэгдэл 141,367.5 сая төгрөг байна. Үүнээс хугацаандаа төлөөгүй зээлийн үлдэгдэл 18,889.8 сая, зээлийн гэрээний хуваарийн дагуу 2022 онд төлөгдөхөөр хүлээгдэж байгаа 17,520.0 сая төгрөг, үлдэх 104,957.7 сая төгрөгийн зээлийг 2028 онд багтаан төлөх үүрэгтэй.

Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны орлого тасарч, санхүүгийн хүндрэлд орсноос Хөгжлийн банкнаас авсан зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй бөгөөд үүнээс шалтгаалан тайлант онд 223.8 сая төгрөгийн нэмэгдүүлсэн хүү төлсөн байна.

Тайлант оны эцсийн байдлаар богино хугацаанд төлөгдөх 36,409.8 сая төгрөгийн зээл, хуримтлагдсан 8,774.7 сая төгрөгийн хүүгийн өртэй бөгөөд энэ компанийн хэвийн үйл ажиллагаа, мөнгөн урсгалд нөлөөлж, тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварт сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсэхээр байна.

Тус компани нь 2016 онд Азийн хөгжлийн банкнаас байгууллагын бүтэц, удирдлагын чадавхыг сайжруулах зориулалтаар 9,492.9 мянган ам.долларын зээл авч зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт 338.5 мянган ам.доллар, зээлийн үлдэгдэл нь хүү ба шимтгэлийн зардлын хамт 9,180.9 мянган ам.доллар буюу 26,154.7 сая төгрөг байна. Уг зээлд Засгийн газар баталгаа гаргасан бөгөөд 2016 онд баталгааны шимтгэлд 5,250.0 мянган ам.доллар буюу 10,529.9 сая төгрөг төлснийг зардлаар бүртгэсэн байна.

Тайлант онд 269.1 мянган ам.доллар буюу 766.6 сая төгрөгийн зээл, 108.9 мянган ам.доллар буюу 310.3 сая төгрөгийн хүү болон баталгааны шимтгэлийн зардал төлсөн байна.

Богино хугацаанд төлөх зээл ба хүүгийн үлдэгдэл 249.6 мянган ам.доллар буюу 711.2 сая төгрөг, үлдэх 8,931.3 мянган ам.доллар буюу 25,443.5 сая төгрөгийг 2031 онд багтаан төлөх үүрэгтэй.

Санхүүгийн тайланд үйл ажиллагааны талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, санхүүгийн зардал гэж ангилсан байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн автозамын урсгал засвар, гэрээт цагдаагийн зардал, Гашуунсухайт авто зам ХХК-ийн үйл ажиллагааны санхүүжилт, зам болон зам дагасан хөрөнгийн элэгдлийг хамруулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт борлуулсан бүтээгдэхүүний өртөг, түүний хэмжилт хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг нарийвчлан заагаагүй байна.

#### **4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл болон компанийн дүрмийн 8.11.1-т заасны дагуу компани болон охин компанийн стратегийн зорилго, зорилт, хөрөнгө оруулалтын бодлого, төсөв, гүйцэтгэх удирдлагын бүтцийг батлах, гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрмийн 9.7 дугаар зүйлд заасны дагуу компани болон охин, хараат компанийн төсөв, төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, ТУЗ-ийн өмнө бүрэн хариуцах үүрэгтэй.

ТУЗ нь 2020 оны 41 дүгээр тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 72,656.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 55,797.2 сая төгрөгөөр, орлогын албан татварын зардлыг 3,314.7 сая төгрөгөөр тогтоож, 13,544.2 сая төгрөгийн ашигтай ажиллах төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр 29,480.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 51,188.4 сая төгрөгийн зардал гарган, 20,146.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, хүүгийн орлогоос 301.4 сая төгрөгийн ашгийн татвар ногдуулсан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 29,480.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 59.4 хувь буюу 43,175.2 сая төгрөгөөр тасарсан нь коронавируст цар тахлын үеийн хил, гаалийн хорионоос шалтгаалан Гашуунсухайт - Тавантолгой чиглэлийн хүнд даацын замаар дамждаг нүүрс тээвэрлэлт эрс буурч замын хураамжийн орлого буурсан нь шууд нөлөөлсөн байна.

Тайлант онд Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд төсвийг хэмнэлттэй зарцуулах бодлого баримталснаар нийт зардлын гүйцэтгэл 51,188.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 11,361.7 сая төгрөг буюу 8.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

**Хөрөнгө оруулалт:** Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 14,910.2 сая төгрөг төлөвлөснөөс үндсэн хөрөнгө худалдан авахад 153.1 сая, биет бус хөрөнгө худалдан авахад 1,200.9 сая төгрөг, төсөл хөтөлбөрт 1,921.1 сая, Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн авто замын засварт 10,628.6 сая, хайгуул үнэлгээний ажилд 777.4 сая төгрөг төсөвлөсөн.

Тайлант онд үндсэн хөрөнгө худалдан авахад 159.3 сая төгрөг, биет бус хөрөнгө худалдан авахад 62.5 сая төгрөг, авто замын хучилт, шинэчлэлтэд 8,457.5 сая төгрөг зарцуулсан. Газрын ховор элемент, Эрчим хүчний экспортын Шивээ энерги, Байгалийн хийн хоолойн Эрдэнэс газ төслийн нэгжүүдэд нийт 1,224.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд үүнээс төсөв хөтөлбөрүүдээр дамжин 1,011.4 сая төгрөгийн зардал гарсан байна.

**Ногдол ашиг:** ТӨБЗГ-ын 2021 он 6 дугаар сарын 24-ны өдрийн 228 тоот тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас 766.6 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээр тогтоосон боловч ТУЗ-аас



төлөх ногдол ашгийн хэмжээг батлаагүй шалтгаанаар ногдол ашгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь санхүүгийн тайланд өр төлбөрийг дутуу илэрхийлсэн бөгөөд үнэн зөв, иж бүрэн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

ТӨБЗГ нь 2020 оны ашгаас төлөх ногдол ашгийг төвлөрүүлэх хугацааг 2022 оны 6 сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

---

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэс Монгол ХХК нь тайлант онд нийт 509.2 сая төгрөгийн 1,116 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 8 мэдээллийг ил тод байршуулаагүй, тайлант оны эхэнд 75 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил гарсан бөгөөд албан шаардлагын дагуу мэдээллийг нөхөн оруулж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 42 тоот тогтоолоор 17,989.8 сая төгрөгийн худалдан авалтын төлөвлөгөөг баталсан байна. Үүнээс 7 удаагийн нээлттэй тендер шалгаруулалтыг цахимаар хийж, 13,148.3 сая төгрөгийн худалдан авалт, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, төсөвлөснөөс 1,688.8 сая төгрөг хэмнэсэн байна. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд 1,872.6 сая төгрөгийн 16 худалдан авалтыг хойшлуулсан ба 3 удаагийн 1,280.0 сая төгрөгийн тендер шалгаруулалт нь амжилтгүй болсон байна.

Худалдан авалтын үйл ажиллагаанд аудитын горим хэрэгжүүлэхэд шалгасан зүйлсийн хувьд материаллаг алдаа илрээгүй бөгөөд ТБОНӨХБАҮХАТ хуулийн хүрээнд шалгасан зүйлс нь холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

---

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 542.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 37.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 310.0 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 195.9 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгснөөс, акт 100.0 хувь, албан шаардлага 83.3 хувь, зөвлөмж 88.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	37.0	2	37.0	-	-	100.0
Албан шаардлага	6	310.0	5	272.8	1	37.2	83.3
Зөвлөмж	9	195.9	8	195.1	1	0.8	88.8
Нийт дүн	17	542.9	15	504.8	2	38.0	90.7

ТӨБЗГ-аас 2019 оны цэвэр ашгаас тогтоосон ногдол ашгийн зөрүү 0.8 сая төгрөгийг төлөөгүй бөгөөд өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн анхаарал татсан дараах асуудлуудыг дараагийн аудитаар шалгах аар шийдвэрлэлээ. Үүнд:

1. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс 1 удаа төлөх тухай хуулийн дагуу 2020 онд Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргаж, иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн үүргийг төлөх гэрээг арилжааны банкт байгуулан, нэг бүр нь 1.0 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 929,861 ширхэг, 929,861.0 сая төгрөгийн Эрдэнэс -1 бондын (жилийн 6%-ийн хүүтэй, 5 жилийн хугацаатай) өр төлбөрийг бүртгэжээ.

Тайлант онд Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 191 дүгээр тогтоолын дагуу 112 ширхэг, 112,000.0 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий үнэт цаасыг нэмж тохируулсан байна. Оны эцэст нийт 929,973 ширхэг, 149,149.7 сая төгрөгийн хөнгөлөлт бүхий 929,973.0 сая төгрөгийн нэрлэсэн үнээрх бондыг Монголбанкинд төлөх өр төлбөрөөр шилжүүлэн бүртгэсэн байна. Бондын өр төлбөрийг тулган баталгаажуулахад Монголбанк нь Капитал болон Хадгаламж банкны 278,000.0 сая төгрөгийн нэрлэсэн үнээрх бондын өр төлбөрийг баталгаажуулан бүртгээгүй байна.

2. Тайлант онд ХААН банк нь Эрдэнэс -1 бондын зөрүү 51.8 сая төгрөгийг Эрдэнэс Монгол ХХК-ийн дансанд шилжүүлсэн бөгөөд уг зөрүүтэй холбоотой тогтоол шийдвэр гараагүй байна.

3. Компани 2021 оны 5 сард багтаан мөнгөжүүлэх Тэтгэвэр барьцаалсан зээл аваагүй иргэнд эзэмшүүлэх нэг бүр нь 1.0 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 194,807 ширхэг, 194,807.0 сая төгрөгийн Эрдэнэс-2 бонд, 1.0 сая төгрөгөөс бага тэтгэвэр барьцаалсан зээлийн үлдэгдэл төлбөртэй иргэнд зөрүү дүнтэй тэнцүү хэмжээний үнэт цаас эзэмшүүлэх 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 21,409.5 сая төгрөгийн Эрдэнэс-3 бонд, нийт 215,216.5 сая төгрөгийн бондын өр төлбөртэй байсан. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 191 дүгээр тогтоолын дагуу Эрдэнэс-2, Эрдэнэс-3 бондыг нийт 721.8 сая төгрөгөөр бууруулж тохируулан, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 215,494.6 сая төгрөгийн бондыг мөнгөжүүлсэн. ҮЦТХТөв нь Эрдэнэс-2, Эрдэнэс-3 бондын олгогдоогүй үлдэгдэл 186.9 сая төгрөгийг буцаан шилжүүлсэн бөгөөд уг зөрүүтэй холбоотой холбогдох тогтоолд өөрчлөлт ороогүй, тохируулга хийгдээгүй байна.



## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 46,773.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.0 сая төгрөгийн алдааг залруулж, 1.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 27,907.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 18,861.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 559.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 18,301.6 сая төгрөгөөс их байгаа тул Сөрөг дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой, үр дүнд нөлөөлөх 4.0 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Тавантолгой түлш ХХК-д оруулсан 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт нь тухайн компанийг үүсгэн байгуулах тогтоол, бусад холбогдох баримтаар нотлогдохгүй байгаа нь Компанийн тухай хууль, 6 дугаар зүйлийн “Охин ба хараат компани: Хэрвээ гаргасан хувьцааны 20-50% -ийг эзэмшиж байвал хараат, түүнээс дээш бол охин компани гэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмээр тогтоосон 3.0 сая ширхэг давуу эрхийн хувьцааг санхүүгийн тайланд тусгахдаа 3.0 сая төгрөгийг Засгийн газраас авах авлагаар бүртгэснийг Сангийн яам баталгаажуулаагүй нь СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр, Компанийн НБББББ-ийн 4.2.1-т заасан авлагыг хүлээн зөвшөөрөх шалгууртай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй;

### 8.2 Төлбөрийн акт

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн тооцоололтой холбоотойгоор 1.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2021 оны 2 сард Ковидын эргүүлд гарсан ажилтанд нэмэгдэл цалин олгохдоо суурь цалингууруу авснаас нэр бүхий 3 ажилтанд 0.7 сая, харилцаа холбооны нөхөн олговрыг биечлэн ажилласан хоногт хувь тэнцүүлэн тооцохдоо 0.9 сая төгрөг тус тус илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 д заасан ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах заалтыг хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 6.4.1- Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

### 8.3 Албан шаардлага

1. Эрдэнэс Монгол ХХК нь 2020 болон түүнээс өмнөх онуудад ТББ, хэвлэл мэдээллийн байгууллагад гэрээт ажлын төлбөр 101.7 сая төгрөг шилжүүлснийг Урьдчилж төлсөн тооцоо дансанд хуримтлуулан бүртгэсэн боловч гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, авлага барагдуулаагүй байгаа нь НББОУС -1, Санхүүгийн тайлангийн толилуулга, параграф 66 в-тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор тухайн хөрөнгийг хэрэгжүүлэхээр хүлээгдэж буй, б- тухайн хөрөнгийг үндсэндээ арилжааны зорилгоор эзэмшиж байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1- Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.4.8- Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоотой харилцагч нартай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулан, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, гэрээг дүгнэж, авлагыг барагдуулах, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх;

2. Өмнөх аудитаас цалин болон дараа тооцоотой холбоотой 37.0 сая төгрөгийн нөхөн төлүүлэх актын төлбөрийг Төрийн санд төвлөрүүлж, холбогдох ажилтнаас авлага үүсгэсэн АХГ-2022/63/НА-СТА-ТӨА

боловч тайлант онд тухайн авлага барагдаагүй, холбогдох ажилтнаас суутгал хийгдээгүй, мөн 2020 онд олгосон 36.3 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа барагдаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэх;

3. Хөгжлийн банкнаас авсан зээлийг гэрээний хугацаанд төлж барагдуулаагүйн улмаас 18,889.8 сая төгрөгийн хугацаандаа төлөгдөөгүй зээл, 8,774.7 сая төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөртэй болсон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн өмчийн хөрөнгө, орлогыг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх, авлагыг цуглуулж, зардлыг хэмнэн, өр төлбөрийг барагдуулах, компанийн төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэх;

4. Тайлант онд хөдөлмөрийн зарга маргааны улмаас нэг ажилтанд 9.4 сая төгрөгийн нөхөн цалин олгох болсон, байгууллагын бүтцээрх алба нэгжийн ажил үүргийн хуваарьт багтсан үүргийг бусдаар гүйцэтгүүлж, 9.9 сая төгрөгийн төлбөр төлсөн, гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр алба хэлтсийн дарга нарт шатахуун, харилцаа холбооны нөхөн олговорт 48.2 сая төгрөг олгосон нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 6.4.1- Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

- **Шийдвэрлэсэн нь:** Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үр ашиггүй зардал гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх;

#### **8.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** НБББББ-т дараах ажил гүйлгээг хэрхэн хэмжиж, хүлээн зөвшөөрч, бүртгэж толилуулах талаар нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Үүнд: Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, Бондын бүртгэл, Замын капиталжуулалт, Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр, Төсөл хөтөлбөр дэх хөрөнгө оруулалтын бүртгэл, тайлагнал, толилуулга, хяналтын талаар нарийвчлан тусгаагүй, СТОУС-16 Түрээс, СТОУС-13 Бодит үнэ цэн стандартын өөрчлөлтөөр нэмэлт оруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасан “Аж ахуйн нэгж нь СТОУС-ыг дагаж мөрдөнө” 18 дугаар зүйлийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Параграф 15-16-д “Санхүүгийн тайлан нь СТОУС-ын бүх шаардлагуудтай нийцсэн биш л бол ААН нь уг санхүүгийн тайланг СТОУС-тай нийцсэн гэж илэрхийлж болохгүй.” гэж зааснаар ирээдүйд санхүүгийн тайланг бүхэлдээ СТОУС-т нийцэхгүй байх эрсдэлтэй.

**Өгсөн зөвлөмж:** Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг СТОУС (НББОУС)-т нийцсэн эсэхийг дахин үнэлж, стандартын өөрчлөлтийг нэмж тусгах, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан бүртгэлийн бодлогыг шинэчлэх шаардлагатай.

## **2. Өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** ТӨБЗГ-ын 2021 оны 228 дугаар тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон 766.6 сая төгрөгийн ногдол ашиг, 2019 оны ногдол ашгийн үлдэгдэл 0.8 сая төгрөгийг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй, хэрэгжээгүй гэрээний дүнгээр хайгуул үнэлгээний хөрөнгө ба өр төлбөрийг 519.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн, балансын өдрөөс хойш 12 сарын дотор төлөгдөх 17,520.0 сая төгрөгийн зээлийг урт хугацаат зээлээр толилуулсан нь НББОУС-1, Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын өр төлбөрийн ангилал, СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр стандартын өр төлбөрийн хэмжилт, хүлээн зөвшөөрөлт, Компанийн НБББББ-ийн 4.7.1-д заасан өр төлбөрийн бодлого, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасан “Аж ахуйн нэгж нь СТОУС-ыг дагаж мөрдөнө” 18 дугаар зүйлийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Өр төлбөрийг НБББББ-т заасны дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах, зөв ангилах, Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тууштай мөрдөж ажиллах.

## **3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант үед 2 удаагийн тендер шалгаруулалтаар "Ай Ти Зон" ХХК-аас нийт бараа худалдан авах 174 сая төгрөгийн гэрээ байгуулж, 54.7 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь НББОУС-16, Үндсэн хөрөнгө стандартын хэмжилт, хүлээн зөвшөөрөлтийн шаардлага хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2. “Нягтлан бодох бүртгэл бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг бүртгэнэ” гэж заасантай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хүлээн авсан хөрөнгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын баримт, бусад холбогдох баримтад үндэслэн данс бүртгэлд тусгах, ашиглаж байгаа ажилтны хөрөнгө ашиглалтын картанд тэмдэглэх, цаашид хөрөнгийг бодитоор хүлээн авч, эдийн засгийн үр өгөөж өгөхөөр аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаа, хөрөнгийн өртгийг найдвартай хэмжиж чадах нөхцөлд хөрөнгийг холбогдох дансанд бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
					Үүнээс		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт нь баримтаар нотлогдоогүй.	Санхүүгийн тайланд залруулна	1	1,000.0	1	1,000.0								
2	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	ТӨБЗГ-т 2019 оны цэвэр ашгаас ногдуулсан ногдол ашгийн зөрүү 813.2 мянган төгрөг, 2020 оны цэвэр ашгаас 766,652.9 мянган төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлээгүй, өр төлбөр үүсгээгүй..	Зөвлөмж өгөх	1	767,466.1									1	767,466.1
3	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Сангийн яамнаас авах авлага баримтаар нотлогдоогүй	Санхүүгийн тайланд залруулна.	1	3,000.0	1	3,000.0								
4	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Хэрэгжээгүй гэрээний дүнгээр хайгуул үнэлгээний хөрөнгө ба өр төлбөрийг илүү илэрхийлсэн	Зөвлөмж өгөх	1	519,000.0									1	519,000.0
5	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Бараа худалдан авах 174 сая төгрөгийн гэрээ байгуулж, зарим хөрөнгө бараа материалыг хүлээн авсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.	Зөвлөмж өгөх	1	54,723.1									1	54,723.1
6	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	2020 онд олгосон цалингийн урьдчилгаа барагдаагүй.	Авлага барагдуулах албан шаардлага	1	36,346.7					1	36,346.7				
7	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	2020 онд тогтоосон актын дүнгээр төлбөрийг төвлөрүүлж, холбогдох ажилтнаас авлага үүсгэсэн боловч авлага барагдаагүй	Авлага барагдуулах албан шаардлага	1	37,000.0					1	37,000.0				
8	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Өмнөх онуудад үүссэн урьдчилж төлсөн тооцоо барагдаагүй гэрээ болон ажлын гүйцэтгэлийг шалгаагүй.	Авлага барагдуулах албан шаардлага	1	101,720.7					1	101,720.7				
9	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	2021 оны 2 сард Ковидын эргүүлд гарсан ажилтанд нэмэгдэл цалин олгохдоо суурь цалинг буруу	Нөхөн төлүүлэх акт	1	715.8				1	715.8					

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			авснаас нэр бүхий 3 ажилтанд илүү олгосон.														
10	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Харилцаа холбооны нөхөн олговрыг биечлэн ажилласан хоногт хувь тэнцүүлэн тооцохдоо илүү олгосон.	Нөхөн төлүүлэх акт	1	871.5				1	871.5						
11	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр газар хэлтсийн дарга нарт шатахуун болон утасны нөхөн олговор олгосон	зөрчил арилгах албан шаардлага	1	48,160.7					1	48,160.7					
12	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Хөгжлийн банкны 2022 онд төлөгдөх хэсгийг Урт хугацаат зээлээр толилуулсан.	Зөвлөмж өгөх	1	17,520,000.0									1	17,520,000.0	
13	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Хөдөлмөрийн зарга маргааны улмаас нөхөн цалин олгосон.	зөрчил арилгах албан шаардлага	1	9,433.3					1	9,433.3					
14	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	байгууллагын алба нэгжийн ажил үүргийн хуваарьт багтсан үүргийг бусдаар гүйцэтгүүлж, төлбөр төлсөн	зөрчил арилгах албан шаардлага	1	9,900.0					1	9,900.0					
15	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	НБББББ-т өртөг, автозам, хойшлогдсон татварын хөрөнгө, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, түрээс, бодит үнэ цэнийн талаар нарийвчлан тусгаагүй.	Зөвлөмж өгөх	1	-									1	-	
16	Эрдэнэс Монгол ХХК	АХГ-2022/63/НА-СТА-ТӨА	Хөгжлийн банкны хугацаандаа төлөөгүй зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй	зөрчил арилгах албан шаардлага	1	27,664,495.2					1	27,664,495.2					
<b>ДҮН</b>					<b>16</b>	<b>46,773,833.1</b>	<b>2</b>	<b>4,000.0</b>	<b>2</b>	<b>1,587.3</b>	<b>7</b>	<b>27,907,056.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>18,861,189.2</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 127/А0150053  
АХГ-2022/63/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны Б/58 тушаалын дагуу Ковид-19 цар тахлаас шалтгаалан бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед нийтийн хэв журмыг сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу 2021 оны 2 дугаар сарын 11-ээс 23-ны өдрүүдэд гудамж талбайд эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласан ажилтнуудад нэмэгдэл хөлс олгохдоо суурь цалинг буруу авснаас шалтгаалж, нэр бүхий 3 ажилтанд 715,789.47 төгрөгийн цалин илүү олгосон.
- Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/6 тушаалын дагуу удирдлагын багийн ажилтнууд болох Тэргүүн дэд, Дэд, Чиглэл хариуцсан захирал, Нэгжийн захирал, дарга нарт харилцаа холбооны нөхөн олговрыг биечлэн ажилласан хоногт хувь тэнцүүлэн олгоогүйгээс шалтгаалж, нэр бүхий 24 ажилтанд 871,515.14 төгрөгийн цалин илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөөлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “Ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтад тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий ажилтнуудад илүү олгосон 1,587,304.62 (нэг сая таван зуун наян долоон мянга гурван зуун дөрөв) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч бөгөөд тэргүүн дэд захирал О.Хулан, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч бөгөөд ахлах нягтлан бодогч А.Мөнхтуяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

У.ОЮУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264080

0001090290





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 538/A0150053  
АХГ-2022/03/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Эрдэнэс Монгол ХХК нь 2020 болон түүнээс өмнөх онуудад төрийн бус болон хэвлэл мэдээллийн байгууллагад гэрээт ажлын төлбөр 101,720,735.82 төгрөг шилжүүлснийг Урьдчилж төлсөн тооцоо дансанд хуримтлуулан бүртгэсэн боловч гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, авлага барагдаагүй байна.
- Өмнөх аудитаас цалин болон дараа тооцоотой холбоотой 37,000,000.00 төгрөгийн нөхөн төлүүлэх актын төлбөрийг Төрийн санд төвлөрүүлж, холбогдох ажилтнаас авлага үүсгэсэн боловч тайлант онд тухайн авлага барагдаагүй, холбогдох ажилтнуудаас суутгал хийгээгүй байна.
- Компанийн ажилтнуудад 2020 онд олгосон 36,346,675.00 төгрөгийн цалингийн урьдчилгаа барагдаагүй бөгөөд өмнөх онд өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх", гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулж алдаа, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч бөгөөд тэргүүн дэд захирал О.Хулан, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч бөгөөд ахлах нягтлан бодогч А.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
У.ОЮУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-206.Docx

0001081392





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 539/А0150053  
АХГ-2022/63/ЛА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд Хөгжлийн банкнаас авсан зээлийн гэрээний дагуу үндсэн зээл, зээлийн хүүг хугацаандаа төлөөгүйн улмаас 223,814,250.87 төгрөгийн нэмэгдүүлсэн хүү төлсөн. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн 18,889,807,589.74 төгрөгийн зээл, 8,774,687,604.26 төгрөгийн хүүгийн өглөгтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 20 дугаар тогтоолоор баталсан 2022 оны төсөвт хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг төлөх талаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн 5.1.2 "Тасралтгүй байх" зарчмыг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Төсвийг зохистой удирдаж, өр үүсгэхгүй байх, хугацаа хэтэрсэн зээл ба зээлийн хүүг төлөх арга хэмжээг зохион байгуулах, дээрх алдаа, зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч бөгөөд тэргүүн дэд захирал О.Хулан, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч бөгөөд ахлах нягтлан бодогч А.Мөнхтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
У.ОЮУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тийрүү-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9010130396  
\\0.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-208.Docx

0001081396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 540/А0150053  
АХГ-2022/03/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/6 тушаалын дагуу удирдлагын багийн ажилтнуудад 48,160,719.69 төгрөгийн шатахуун болон харилцаа холбооны нөхөн олговор олгосон байна.
- 2021 онд ажлаас чөлөөлөгдсөн 7 ажилтан хөдөлмөрийн маргаан үүсгэсэн бөгөөд тайлант онд 1 ажилтан шүүхийн шийдвэрээр ажилгүй байх хугацааны 9,433,361.00 төгрөгийн цалинтай тэнцэх нөхөн олговор төлж, үр ашиггүй зардал гаргасан.
- Гэрээ эрх зүй, хамтын ажиллагааны газар нь гүйцэтгэх удирдлага нэгжийн үйл ажиллагаанд хуулийн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд хууль зүйн дүгнэлт гаргах үүрэгтэй боловч хөдөлмөрийн маргааны асуудлаар 9,900,000.00 төгрөгийн төлбөр төлж, зөвлөх үйлчилгээ авч, үр ашиггүй зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,"; 10.1.7 "Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах;" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч бөгөөд тэргүүн дэд захирал О.Хулан, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч бөгөөд ахлах нягтлан бодогч А.Мөнхтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

У.ОЮУНАА

